

ХОРИНХОЁРДУГААР БААЗ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

“Хоринхоёрдугаар бааз” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14 цагт компанийн төв байрны хурлын танхимд хуралдав.

Хурал зохион байгуулах комиссын дарга З.Туул хурлыг нээж хурлын ирцийг танилцуулав.

З.Туул: - Сайн байцгаана уу Энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулья. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Хувьцаа эзэмшигч З.Номундарь 1,668,033 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/, Хувьцаа эзэмшигч Т.Эрдэнэбаатар 89,020 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/, Хувьцаа эзэмшигч Л.Гүндэгмаа 18,808 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/, Хувьцаа эзэмшигч “Монгол секюритиес” ХК 380,940 ширхэг хувьцааны саналаар /ТУЗ-ийн дарга/, Хувьцаа эзэмшигч “Чингисхаан Секьюритес” ХХК 56,870 ширхэг хувьцааны саналаар /Үүсгэн байгуулагч, захирал/ нар оролцож байгаа нь нийтдээ 2,213,671 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа энгийн хувьцааны 83.3 хувийг эзэмшигчид хуралд оролцсоноор хурлын ирц хуулийн шаардлагад нийцэж, хурал хуулийн дагуу хүчин төгөлдөрт тооцогдож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн ТУЗ-ийн гишүүдээс Л.Гүндэгмаа, Т.Зоригтбаатар, З.Номундарь, Т.Эрдэнэбаатар, Б.Баярсайхан, Ц.Энхтүяа нар оролцож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд “Хоринхоёрдугаар бааз” ХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар, Тооллогын комиссын дарга Д.Солонго, тооллогын комиссын гишүүн М.Нэргүй, хурал зохион байгуулах комиссын дарга З.Туул, хурлын нарийн бичгээр З.Түяа нар оролцож байна.

Хурал даргалагчаар олонхи хувьцаа эзэмшигч З.Номундарийг сонгох саналтай байна. Эс зөвшөөрсөн хүн байхгүй бол хурал даргалагчаар З.Номундарийг сонгоё /Санал нэгтэй сонгов/.

Хурал даргалагч З.Номундарь: -За хэлэлцэх асуудлын дарааллын дагуу компанийн Гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

Т.Зоригтбаатар: -Сайн байцгаана уу. Манай компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл үл хөдлөх хөрөнгө түрээслэх үйл ажиллагаа явуулж ирсэн. Манай компанийн гаргасан хувьцааны нийт энгийн хувьцааны тоо 2,651,170 ширхэг. Өмнө жилийн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс эзэмшил газар болон үл хөдлөх эд хөрөнгөнөөс хэсэгчлэн худалдаж, шилжүүлэх талаар шийдвэр гаргасан бөгөөд энэ дагуу худалдан авах сонирхолтой гуравдагч этгээдтэй холбогдох гэрээ хэлцэл байгуулсан байгаа.

2025 оны үйл ажиллагааны санхүүгийн тайланг нягтлан М.Нэргүй танилцуулна.

М.Нэргүй: -Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би нягтлан бодогч Нэргүй байна. 2025 оны санхүүгийн тайланг танилцуулья. Манай компанийн эргэлтийн хөрөнгө 12 тэрбум төгрөг, үүнээс

биет бус хөрөнгө нь 499 сая төгрөг, эзэмшигчдийн өмч 11,14 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 10,9 тэрбум төгрөг.

2025 онд улсад нийт 1,3 тэрбум төгрөгийн татвар төлсөн. Үүнд: нийгмийн даатгалын шимтгэлд 36,6 сая төгрөг ХХОАТ-т 14,7 сая төгрөг, НӨАТ-т 419,4 сая төгрөг, ҮХЭХАТ-т 17,3 сая төгрөг, газрын төлбөрт 77,1 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 795,3 сая төгрөгийг тус тус төлсөн.

2025 оны түрээсийн орлого 324.5 сая төгрөг, газар болон үл хөдлөхийн эрх шилжүүлсэн 12 тэрбум орлого орсон. Зардлын хувьд 385,9 сая төгрөгийн зардал гарсан, борлуулсан бүтээгдэхүүний орлого буюу 226,5 сая төгрөг, цэвэр ашиг 10,9 тэрбум төгрөг. Цаашдийн үйл ажиллагаа бүтээн байгуулалтын зардалд шаардагдах хөрөнгийг авч үлдээд тодорхой хэмжээний буюу 500 орчим сая төгрөгийн ногдол ашиг зарлахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэсэн байгаа.

Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ 4126 төгрөг.

Компанийн сүүлийн 5 жилийн эдийн засгийн ерөнхий судалгааг шинэчлэн гаргасныг хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулж байна.

Өнгөрсөн жил нэгж хугацаанд ногдох ашгийн хэмжээ 9.82 төгрөг байсан бол энэ жил 4,126 төгрөг болсон байна. Эргэлтийн хөрөнгө өссөн, эргэлтийн бус хөрөнгө үндсэн хөрөнгө буурсан учраас буурсан, нийт хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн, өр төлбөрийн хэмжээ өссөн энэ нь НӨАТ-ын өглөгтэй байгаа.

Эзэмшигчдийн өмч өссөн, борлуулалтын орлого өссөн, зардал буурсан ашиг өссөн байна. 2025 оны зардал нийт 1,2 тэрбум төгрөг үүний 67 хувь татварын зардал 15% цалин хөлсний зардал байна.

Манай компанийн аудитыг “Цэбэ Консалтинг Аудит” ХХК хийсэн бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй компани, аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй.

Хурлын дарга З.Туул: -За санхүүгийн тайланг сонслоо асуух тодруулах зүйл байхгүй бол одоо санал хураалтандаа орьё, та бүхэн санхүүгийн үйл ажиллагааны тайланг батлах бол санлаа өгнө үү. Хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр тайланг батлав.

Дараачийн хэлэлцэх асуудал ногдол ашиг тараах тухай асуудал байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 26/1 дугаартай “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоол гарсан бөгөөд уг тогтоолоор “Хоринхоёрдугаар бааз” ХК-ийн 2025 оны тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 12,042,325,377.04 төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 499,000 эргэлтийн хөрөнгийг 12,041,826,377.04 төгрөгөөр, нийт орлогыг 12,344,749,059.34 төгрөг, ашиг 9,533,317,541.25 төгрөгөөр тус тус тооцож тайлан тэнцлийн дүнг баталсан байгаа.

Түүнчлэн, Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 498,419,960 /Дөрвөн зуун ерэн найман сая дөрвөн зуун арван есөн мянга есөн зуун жаран/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэр гарсан.

Уг ногдол ашгийг компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанд хуваавал нэгж хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа нэгж хувьцаанд ногдох хэмжээг 188 /нэг зуун наян найм/ төгрөгөөр тогтоосон байна.

Мөн ТУЗ-ийн тогтоолд ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэх өдрөөр тогтоох ёстой.

Тиймээс энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулах шаардлагатай байна. За ингээд санал хураах энэхүү саналын хуудсын 4 дэх хэсэгт саналаа өгнө үү. Санал хурааж дуусав.

Хэлэлцэх асуудлыг хамгийн сүүлд “Бусад” гэсэн асуудал байгаа бөгөөд энэ талаар та бүхэн өөр хэлэлцүүлэх асуудал байгаа бол саналаа хэлж болно. Та бүхэнд ямар нэгэн санал байна уу?

Хувьцаа эзэмшигч З.Номундарь: -Дараагийн хурал дээр ТУЗ-ийн гишүүнийг солих хүсэлтэй байна. Хуралд оролцдоггүй ТУЗ-ийн гишүүдийг солих шаардлагатай болов уу. Өөр санал байхгүй бол саналаа аваад хурлаа дуусгая.

Саналын хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д.Солонго танилцуулав

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 15:00 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА		З.НОМУНДАРЬ
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН		З.ТУЯА